

БАТЛАВ.

НИЙСЛЭДИЙН ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

 Г.БАЯРСАЙХАН

ГЭР ХОРООЛЛЫН ГУДАМЖ ЗАМУУДЫГ ХУСАЖ, ТЭГШИЛЖ НЯГТРУУЛАХ АЖЛЫН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ /СХД, 23 ДУГААР ХОРОО/

| | |
|--|---|
| 1. Ерөнхий зүйл | Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хорооны гэр хорооллын шороон гудамж замуудыг хусаж тэгшлэх, нягтруулах ажил. |
| 2. Ерөнхий төлөвлөгөө, барилгын талбайн үзүүлэлт | Одоо байгаа шороон зам, гудамж нь хотгор гүдгэр ихтэй, үргэлжилэн орсон аадар борооны улмаас ховил үүсч тээврийн хэрэгсэл болон явган зорчигчийн хөдөлгөөнд хүндрэлтэй байдал үүссэн байна. |
| 3. Ажлын цар хүрээ | Гудамжны өргөн 4 - 8 м ба хусч тэгшлэх, шаардлагатай байна. |
| 4. Ажлын хил хязгаар | Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хороо ажлын тоо хэмжээг хавсралтаар үзүүлэв. |
| 5. Засварын ажлын зохион байгуулалт | <p>а. Засварын ажлын хуваарь, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах.</p> <p>Ажлыг гүйцэтгэхдээ өөрийн гүйцэтгэж байгаа ажил, явганаар зорчиж байгаа иргэдэд бэрхшээл учруулахгүй байхаар анхааруулах, хориглох тэмдэг, засварын ажил явагдаж буйг мэдээлэх тэмдгүүдийг засварын ажил хийгдэж байгаа орчинд зайлшгүй байрлуулна. Шөнийн цагаар гэрэлтүүлэх хэрэгсэл болон гэрэл ойлгогч түмбэ, цацуулагчтай тууз зэргийг ажлын талбайд хангалттай байрлуулах шаардлагатай. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах нөхцөлд холбогдох байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, оршин суугчдын ая тухтай зорчих байдлыг ханган ажиллаж, зохих зөвшөөрлийг авсан байх талаар анхаарч барилгын ажлын зохион байгуулалт, хөдөлмөр хамгаалалын аюулгүй ажиллагааг нарийн баримтлан ажиллах шаардлагатай. Шороон зам хусаж тэгшлэх үед инженерийн шугам сүлжээ, цахилгааны кабель гэмтээх тохиолдолд гүйцэтгэгч хариуцлага хүлээх бөгөөд урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг ханган ажиллана. НАЗХГ-ын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар баталсан “Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага”-ыг баримтлан гүйцэтгэнэ. Ажил хийж байгааг анхааруулсан тэмдэг хаалтыг зохих журмын дагуу тавина.</p> <p>а. Засварын ажил гүйцэтгэх технологи</p> <p>Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хорооны хотгор, гүдгэр ихтэй тээврийн хэрэгслээр зорчиход хүндрэлтэй гэр хорооллын шороон гудамж замуудыг автогрейдерээр жигд тэгшлэн, өөрөө явагч 12-18 тн даацтай далангийн индүүгээр нягтруулна. Нягтралын үр дүн 98%-аас багагүй байна.</p> |

| | |
|----------|--|
| | Хөдөлгөөн ихтэй гудамж зам дээр замын ажилчид болон зорчигчдын аль алинд нь аюултай тул засварын ажил хийж байх үед хаалт, замын тэмдэг, туг дарцаг байрлуулах зэргээр хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авна. |
| 6. Бусад | Хусч тэгшлэх, нягтуулах ажлыг м2-аар хэмжинэ. Ажлын үе шат бүрт нэг цэгээс фото зураг авч, далдлагдсан ажил бүр дээр акт бичиж, инженерээр баталгаажуулна. |

Тендерт оролцогч гэрээт ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай

мэргэжлийн инженер техникийн ажилчид:


| Мэргэжил /онцлогууд/ | | Тоо | Ажлын туршлага /жил/ |
|---------------------------|-----------------------------|-----|----------------------|
| Инженер техникийн ажилчид | Авто замын инженер | 1 | 1-ээс дээш |
| | Материалын инженер | 1 | 1 ба түүнээс дээш |
| | Хөдөлмөр хамгааллын инженер | 1 | 1 жил |
| | Нийт | 3 | |

Тендерт оролцогч гэрээт ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай

машин механизмууд:


| No | Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр | x/n | Тоо | Хүчин чадал | Тайлбар |
|----|--|-----|-----|-------------|---------------------|
| 1 | Усны машин | шр | 1 | 5 тн | Өөрийн болон түрээс |
| 2 | Индүү /далангийн доргиурт/ | шр | 1 | 12-18 тн | Өөрийн болон түрээс |
| 3 | Автогрейдер | шр | 1 | 105 м.х | Өөрийн болон түрээс |
| 4 | Бага оврын ачааны машин | шр | 1 | 1-3 тн | Өөрийн |

Хянасан:

ЗАХХ-ийн дарга  О.Энхбаатар

ЗАХХ-ийн ахлах мэргэжилтэн  Б.Ганбат

Боловсруулсан:

ЗАХХ-ийн хяналтын мэргэжилтэн  Т.Чингэс